

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ-ЫН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025 оны 12 дугаар сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Хийгдэх ажил	Ажлын гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, захирааны удирдлага, дотоод ажлын үр дүнг сайжруулахад чиглэсэн хяналт шалгалт			
1	Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагын холбогдох газарт тайлагнах.	Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн. Нийт 5 ажлыг хяналтад авч зохион байгуулсны хэрэгжилт 90 хувьтай үнэлэгдсэн байна.	Үр дүн гарсан 90%
2	Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтүүдийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж, холбогдох газарт тайлагнах	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-т хэрэгжиж буй Засгийн газрын тогтоол, НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолын хэрэгжилтэд хяналт тавин ажиглав. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн биелэлт 90% тай байна.	Үр дүн гарсан 90%
3	Төсвийн шууд захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагчтай 2025 онд байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж холбогдох газарт тайлагнах	Төсвийн шууд захирагчаас төсвийн ерөнхийлөн захирагчтай 2025 оны 01 сард Хариуцлагын гэрээ байгуулсан бөгөөд Нийслэлийн Засаг дарлын Тамгын газрын Төрийн захиргаа, удирдлагын хэлтэст байгууллагын дарлын Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хүргүүлсэн. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж холбогдох газарт хүргүүлэн ажиглав. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр гүйцэтгэл 92,9 хувьтай үнэлэгдэж, эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлттэй харьцуулахад 16 хувиар өссөн дүнтэй байна. Үүнд: ➢ 2025 оны эхний хагас жилийн байдлаар 85 буюу түүнээс дээш хувь "бүрэн хангалттай" 15 арга хэмжээ, 70-85 хүртэл хувь буюу "хангалттай" 10 арга хэмжээ, 70 хүртэл хувь "хангалтгүй" 8 төлөвлөгөөний хэрэгжилт арга хэмжээ байгаа бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нийт 78,04 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. ➢ 2025 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 85 буюу түүнээс дээш хувь "бүрэн хангалттай" 29 арга хэмжээ, 70-85 хүртэл хувь буюу	Үр дүн гарсан 100%

		"хангалттай" 2 арга хэмжээ , 70 хүртэл хувь "хангалтгүй" 2 төлөвлөгөөний хэрэгжилт арга хэмжээ байгаа бөгөөд гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт нийт 92.9 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж байна.	
4	Нийслэлийн Засаг дарга, Хотын ерөнхий менежер болон Газрын даргын шуурхай зөвлөгөөнөөр өгсөн үүрэг даалгавар, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж тайлагнах	Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын шуурхай хуралдаан 14 хоног тутамд 1 болдог бөгөөд 2025 оны эхний 11 сарын байдлаар 22 удаагийн шуурхай хуралдааны биелэлтийг хүргүүлэн ажилласан. Нийслэлийн удирдах ажилтны шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг Улаанбаатар.тп сайтад нэгтгэрч тухай бүр нь хүргүүлэн ажиллаж байна.	Үр дүн гарсан 100%
5	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллана.	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-т 2025 онд Өргөдөл, гомдлын нэгдсэн системээр 22 өргөдөл ирсэн бөгөөд нэг өргөдөл нь хаяг андуурч ирсэн зөрчилтэй байна. Байгууллагын ажилтнуудаас ажилд томилогдох 11, ажлаас чөлөөлөгдөх 6, ээлжийн амралтын 33, хүүхэд асрах чөлөө 1 нийт 51 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан байна.	Үр дүн гарсан 100%
6	МУЗГ, НЗД-ын сахилга харилцаага, дэг журмыг сайжруулах тухай албан даалгаврууд, тогтоолын хэрэгжилтийг хангаж, байгууллагын дотоод журам, албан хаагчдын сахилга харилцаага, ёс зүйн хэм хэмжээг сахуулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн бүртгэл, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж зөрчил, дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулах	Ажлын цаг ашиглалтыг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын компьютеруудыг олон нийтийн сүлжээнд ажлын цагаар нэвтрэх эрхийг хаасан бөгөөд цаг ашиглалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нүүр танин бүртгэчийг Егр.улаанбаатар.тп сайтад холбон ажилласан. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын 2023 оны А/17 дугаар тушаалаар тооллогын комиссыг гарган байгууллагын эд хөрөнгө бараа материалыг тоолсон бөгөөд эд хөрөнгийн зөрчил үүсээгүй.	Үр дүн гарсан 100%
7	Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, удирдлагыг мэдээллээр хангах	Байгууллагын ил тод байдлыг хангах чиглэлээр мэдээлэл технологийн ажилтан, хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн нарт мэдээлэл өгч "Мэдээллийн ил тод байдлын тухай хууль"-ийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллав. Ил тод байршуулах мэдээллийн жагсаалтыг гаргаж, хариуцах ажилтныг үүрэгжүүлсэн. Байгууллын цахим хуудсанд 19 төрлийн 63 мэдээлэл байршуулан ажилласан.	Үр дүн гарсан 100%
8	Байгууллагын хүний нөөцтэй холбоотой тайлан, мэдээнд хяналт тавих үнэлгээ хийх	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-т 2025 онд 57 б тушаал гарсан бөгөөд нийт 24 хүн шинээр ажил томилогдож, 17 хүн	100%

		чөлөөлөгдөж, 11 хүнийг сэлгэн ажиллуулах тушаал гарсан байна. Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн их байгаа нь цаплигийн хэмжээ ажлын ачаалал зэргээс шалтгаалж байна гэж үзэж байна. Хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт, ил тод байдлад хяналт тавин ажилласан.	Үр дүн гарсан
Зорилт 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд явуулах дотоод хяналт			
9	ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих	"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын тохижилт үйлчилгээний хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартыг мөрдөн ажиллаж байна. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Тохижилт, үйлчилгээний албаны 13 албан хаагчдад дотоод сургалт хийсэн байна Мөн Хүй долоон хуада дахь ажилчдад Тохижилт үйлчилгээний албаны ашиглалтын инженер өглөө бүр хөдөлмөрийн аюулгүй байдлын зөвлөгөө өгч ажлын дэвтэрт гарын үсэг зурруулан ажиллаж байна. Мөн шаардлагатай бараа материалаар байнга ханган ажилладаг. Энэ жил ХАБЭА талаар ямар нэгэн зөрчил гараагүй.	90% Үр дүн гарсан
10	Байгууллагын эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалтын байдал, өмч хамгаалах зөвлөлийн хурлын үйл ажиллагаанд тодорхой арга аргачлалаар хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авах.	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу "Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ын даргын А/19 тушаалаар Өмч хамгаалах байнгын зөвлөл"-г байгуулсан. Байгууллагын дэргэдэх өмч хамгаалах зөвлөл нь 10 дугаар сарын 30-ны байдлаар 4 удаа хуралдаж хурлаас гарсан шийдвэрийг тухай бүрт газрын даргад танилцуулан Нийслэлийн Өмчийн харилцааны газарт албан бичиг хүргүүлсэн. Нийслэлийн өмчийн харилцааны газраас 2025 оны 04 сард явуулсан 2024 оны жилийн эцсийн актлах хүсэлтэй хөрөнгийн албан бичгийн хариу 2025 оны 06 дугаар сарын 26-нд А/153, 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/591 өдөр тушаал байгууллагын программаас хасаж ажилласан байна.	100% Үр дүн гарсан
11	Үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа цогцолборт байрлах эд хогшил, хөрөнгийн ашиглалтын /гэр бааз, машин механизм, бие засах газар, гүүрэн болон бусад байгууламж/ хэвийн байдалд үзлэг шалгалт явуулж бэлэн байдлыг хангах.	Үндэсний Их баяр наадам болон Хүй долоон хуудат зохион байгуулагддаг үндэсний их баяр наадам, олон нийтийн арга хэмжээнд ашиглагддаг эд хөрөнгө, машин механизмын бүрэн бүтэн байдлад Үндэсний Их баяр наадамын бэлтгэл ажил болон бусад арга хэмжээ наадамын ажлын төлөвлөгөөний дагуу техникийн комиссын хамт хяналт тавин ажилласан. Байгалийн гамшигт үзэгдэл болох хүчтэй салхи, аадар борооны улмаас 2025 оны 07 дугаар сарын 24-ний шөнө "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Хүй долоон хуудат байрлах агуулах, барилга байгууламж, гэр баазад үүссэн эвдрэл гэмтлийн зэргийг Онцгой байдлын газрын дүгнэлт, мэргэжлийн байгууллагаар гамшигт өртсөн хөрөнгийн үнэлгээг тооцуулан гаргуулах, сэргээн босгох ажлыг зохион байгуулах газрын даргын №А/25 дугаартай тушаалаар ажлын хэсэг	100% Үр дүн гарсан

	актаар хүлээлцэх, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулах, хадгаламжийн нэрх үүсгэх	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	ажиллаж байх талаар Хүний нөөц болон Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэнд үүрэг чиглэл өгч ажиллав.	
4	Ажилтан болон албан хаагч ажлаас чөлөөлөгдөх, өөрчлөгдсөн тохиолдолд ажил хүлээлцэх комиссын бүрэлдэхүүнд архив, бичиг хэргийн ажилтныг оруулдаггүй	Хүний нөөцийн мэргэжилтэн	Даргын № дугаартай тушаалаар батлагдсан "Ажил хүлээлцэх комисс"-т архив, бичиг хэргийн мэргэжилтнийг комиссын гишүүнээр томилон ажиллуулж байна.	100%

Хоёр.Баримт бичгийн зохион бүрдүүлэлт, стандартын хэрэгжилт

5	Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлал, зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийг холбогдох хууль журам, стандартын дагуу бүрдүүлээгүй.	Тогтоол шийдвэрийн биелэлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн захирамж, зохион байгуулалт, мэдээлэл лавлагаатай холбоотой баримт бичгийг холбогдох хууль журам, стандартын дагуу бүрдүүлж ажиллах талаар ажил хариуцсан мэргэжилтэн нарт үүрэг даалгавар өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.	50%
6	Баримт бичгийг зохион бүрдүүлэхдээ цаасны захын хэмжээг тохируулаагүй хуудсыг дугаарлаагүй, хүснэгтэн хэлбэрээр боловсруулахдаа мөр, баганын дугаар оруулаагүй	Тогтоол шийдвэрийн биелэлт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн	Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн "Албан хэрэг хөтлөлт"-ийн тухай хууль, журыг хэрэгжилтийн сайжруулах зорилгоор нийт албан хаагчдад сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	50%

		байгуулж нарийн бичгээр ажиллав. Байгалийн гамшгаас үүдэлтэй сэргээн босгох, цэвэрлэгээ үйлчилгээний ажилд давхардсан тоогоор нийт 56 албан хаагч, ажилтан хамрагдан ажиллав.	
12	Улсын их баяр наадмын хөрөнгө оруулалтаар хэрэгжих үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч зөвлөмж өгөн ажиглах	"Үндэсний Их Баяр наадам"-ын батлагдсан санхүүжилт 126,924,000.0 /нэг зуун хорин зургаан сая есөн зуун хорин дөрвөн мянга/ сая төгрөг, нэмэлтээр 151,395,200.0 /нэг зуун тавин нэгэн сая гурван зуун ерөн таван мянга хоёр зуу/ төгрөгийн санхүүжилт авч нийт 278,319,200.0 /хоёр зуун далан найман сая гурван зуун арван ес хоёр зуу/ төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна. "Хүрээ-Цам Даншиг наадам"-ыг зохион байгуулахтай холбоотой тохижилт үйлчилгээний ажлын зардалд 230,881,000.0 / хоёр зуун гучин сая найман зуун наян нэгэн мянга/ төгрөгийн санхүүжилт авч ажилласан. Баяр наадмын бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх гэрээ, гэрээ дүгнэсэн актуудыг хуулинд нийцсэн эсэхэд хяналт тавин ажилласан. Тайлант хугацаанд нийслэлийн төсөвт 235.2 сая төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөнөөс III-р улирлын байдлаар тайлант хугацаанд 343,692,300 сая төгрөгийн орлого бүрдүүлэн ажилласан.	100% Үр дүн гарсан
13	Байгууламжийн дэд бүтэц, цахилгаан хангамжийн байдалд үзлэг шалгалт явуулж, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээ авах	Хүй долоон худал дах цахилгаан хангамж доголдож кабель шугам гэмтсэн тул УБЦТС ТӨХК-ийн кабелийн ашиглалтзасварын төвтэй 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр МНЦ 23/06 тоот гэрээ байгуулж засварлуулах ажлыг гүйцэтгүүлсэн. Гэрээний үнэ 5,303,000 төгрөг	100% Үр дүн гарсан

Дундаж хувь

97.6%
Үр дүн гарсан

ТАНИЛЦСАН:
ДАРГА

Д.ОТГОНБААТАР

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Н.БАТТӨГС

